



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ
ᠵᠢᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/208

Алтай хот

**Арга хэмжээний нээлтийг "Алтайн
магтаал"-аар эхлүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Соёлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны "Аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" 10 дугаар тогтоол, "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 2.4 дэх зорилгыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд аймгийн Засаг даргын Тамгын газар, харьяа хэлтэс, агентлаг, албан байгууллагууд, сумдаас зохион байгуулж буй аливаа томоохон арга хэмжээний нээлтийн үйл ажиллагааг "Алтайн магтаал"-аар эхлүүлж байхаар тогтсугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сум, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (С.Мөнжаргал)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР